



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/675

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр дэх Улсын тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын байгууллага, жуулчны баазуудад газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Хуншагай -аймгийн Татварын газрын дарга
Гишүүд: Б.Батбилгүүн -Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Базардамбуу-аймгийн Статистикийн хэлтсийн дарга
П.Мөнхжаргал -аймгийн Байгаль орчны газрын дарга
Ж.Төмөрсүх -Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга
Х.Бүрэнжаргал-Рэнчинлхүмбэ сумын Засаг дарга
Д.Батцэнгэл -Улаан-Уул сумын Засаг дарга
Б.Бямбабаяр -Ханх сумын Засаг дарга
Д.Отгонсүрэн -Цагааннуур сумын Засаг дарга
А.Баттүшиг -Хатгал тосгоны захирагч

Нарийн бичгийн дарга:

Б.Мөнгөнзул - аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

2.Улсын тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг зохион байгуулж, үр дүнг 2025 оны 2 дугаар улиралд багтаан танилцуулахыг ажлын хэсэг (Ч.Хуншагай)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012118